**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/57 Бор-Өндөр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 албан даалгавар, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/191 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах зорилгоор Аймгийн Засаг даргын нэрэмжит “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-т бэлтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

| | |
|---|---|
| Х.Галбадрах | Засаг даргын орлогч |

Нарийн бичгийн дарга

| | |
|---|---|
| Б.Баярбаясгалан | Байгаль хамгаалагч |

Гишүүд:

| | |
|---|---|
| П.Энх-Амгалан | Хөдөө аж ахуйн тасгийн дарга |
| М.Мөнхцэцэг | Нягтлан бодогч |
| Б.Цогзолмаа | Холбоо 2 дугаар багийн зохион байгуулагч |

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.АДЪЯАБИЛЭГТ

D:/bichig hereg/Захирамж.docx